# ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2026 оны 06 дугаар сарын 22 Улаанбаатар хот

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн байгууллагад холбогдох заалт, шийдвэрээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний 2026 оны хагас жилийн тайланд тулгуурлан Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их хурлын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын даалгаврын байгууллагад хамаарах нийт 33 шийдвэрийн 53 зүйл, заалтыг хэрэгжүүлэн ажилласныг хяналтад авч Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж дүгнэв.

Хяналтад авсан 33 шийдвэрийн 53 зүйл, заалтаас “хэрэгжсэн” буюу 100 хувьтай 44 зүйл, заалт, тодорхой үр дүнд хүрсэн буюу “хэрэгжих шатандаа” 8 зүйл, заалт, “хэрэгжих боломжгүй” 1 зүйл, заалт байгаа нь дундаж үнэлгээгээр 92.3 хувь үнэлэгдлээ. (Хүснэгт 1.)

(Хүснэгт 1.)

| | | | Бүгд | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хууль | УИХ-ын тогтоол | УИХ-ын Байнгын хорооны тогтоол | Ерөнхийлөгчийн зарлиг | ҮАБЗ-ийн зөвлөмж | ҮАБЗ-ийн хуралдааны | ЗГ-ын тогтоол | Ерөнхий сайдын захирамж | ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | Албан даалгавар |
| Гурав. Засаглал | | | | | | | | | | | | | |
| Эрх зүйн орчин<br>Мэдээллийн технологи хөгжүүлэлт, нэвтрүүлэлт<br>Төрийн мэдээллийн ил тод байдал | | | | | | | | | | | | | |
| Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо | | | 33 | 2 | 1 | 3 | 2 | 6 | - | 6 | 1 | 9 | 3 |
| Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо | | | 53 | 4 | 1 | 7 | 3 | 9 | - | 7 | 2 | 10 | 10 |
| Үнэлгээ | Хэрэгжсэн | | 44 | 3 | 1 | 6 | 3 | 7 | - | 7 | 2 | 6 | 9 |
| | Хэрэгжих шатандаа | Тодорхой үр дүнд хүрсэн | 8 | 1 | - | 1 | - | 1 | - | - | - | 4 | 1 |
| | | Удааш-ралтай/ эрчимжүү | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | лэх шаардлагатай | | | | | | | | | | | |
| | Хэрэгжээгүй | Зохион байгуулалтаас | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| | | Хөрөнгө дутагд-санаас | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| | Хугацаа болоогүй | | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| | Хэрэгжих боломжгүй | | 1 | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| | Хяналтаас хасуулах санал (хүчингүй болсон эсэх) | | 7 | 4 | - | - | - | - | - | - | - | 1 | 2 |
| Дүн (хувь) | | | 92.3 | 87.5 | 100 | 92.8 | 100 | 93.7 | - | 100 | 100 | 80 | 95 |

Монгол Улсын хуулийн хэрэгжилт (Хүснэгт 2.)

| Д/д | Зүйл, заалт дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Дундаж хувь |
|---|---|---|---|
| Гурав. Засаглал | | | |
| 1 | 22.2. Энэ хуулийн 22.1.2-т заасан өвчний жагсаалтыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална; | Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2020-12-31 Дугаар 2020.12.31 | 50 |
| 2 | 401.5. Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг ашиглах, мэдээлэл нийлүүлэх, солилцох журмыг хууль зүйн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална; | | 100 |
| 3 | 18.5. Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон журмыг Засгийн газар батална; | Аялал жуулчлалын тухай 2023-05-04 Дугаар 2023.05.04 | 100 |
| 4 | 20.4. Үндэсний хорооны ажиллах журмыг Засгийн газар батална; | | 100 |
| Хэсгийн дундаж үнэлгээ | | | 87.5 |

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт (Хүснэгт 3.)

| Д/д | Зүйл, заалт дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Дундаж хувь |
|---|---|---|---|
| Гурав. Засаглал | | | |
| 1 | 2.2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ), аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ёс зүйн хороо, Засгийн газрын, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, бүх шатны томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасугай; | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2024-04-18 | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | Дугаар 2024_27 | |
| Хэсгийн дундаж үнэлгээ | | | 100 |

## Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоолын хэрэгжилт (Хүснэгт 4.)

| Д/д | Зүйл, заалт дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Дундаж хувь |
|---|---|---|---|
| Гурав. Засаглал | | | |
| 1 | 1.2. Монгол Улсын Засгийн газар хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэн шийдвэр гаргахдаа төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжид заасан зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлагад нийцүүлж байх; | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023-11-01 Дугаар 2023_10 ЁЗСХБХ | 100 |
| 2 | Байнгын хорооны 2023 оны 10 дугаар тогтоолын 1 дэх заалтын 1, 3, 6. 7. 8. 9 дэх дэд заалтад заасан арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, нийгмийн болон монгол хүний ёс суртахууны түвшин, чиг хандлагыг тодорхойлох суурь судалгаа хийж, судалгаанд суурилсан бодлого боловсруулах; | Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай 2024-11-06 Дугаар 2024_06 ЕЗДБХ | 50 |
| 3 | Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" (2024-2030)-ийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангаж, жил бүр тайлагнах; | | 100 |
| 4 | Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллах; | | 100 |
| 5 | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл болон гомдол, мэдээлэл, зөрчил, хариуцлагын нэгдсэн бүртгэлийн системийг сайжруулж, тогтмол хэрэглээнд хэвшүүлэх; | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-06-10 Дугаар 2025_04 ТББХ | 100 |
| 6 | Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын томилох эрх бүхий  албан тушаалтнуудад: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн  хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшууллын  асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн үр дүнг тооцож ажиллах; | | 100 |
| 7 | Тогтоолын хэрэгжилтийг хангаан УИХ-ын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ) | | 100 |
| Хэсгийн дундаж үнэлгээ | | | 92.8 |

## Ерөнхийлөгчийн зарлиг хэрэгжилт (Хүснэгт 5.)

| Д/д | Зүйл, заалт дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Дундаж хувь |
|---|---|---|---|
| Гурав. Засаглал | | | |
| 1 | Иргэн, аж ахуйн нэгжийн тарьсан модоор ойн санг бүрдүүлж, түүнийг улсын нэгдсэн санд бүртгэх, тарьсан модыг зах | | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | зээлийн эргэлтэд оруулж энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулахад нь бодит дэмжлэг үзүүлэх болон гадаад улсаас Монгол Улсад ирж буй хүн бүр монгол оронд мод тарих санаачилгыг өрнүүлэх; | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58 | |
| 2 | Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай; | | 100 |
| 3 | Жил бүрийн 5, 9 дүгээр саруудын Бямба, Ням гарагуудыг тэрбум мод тарих үндэсний өдөр болгон зарласугай;<br>2. Тэрбум мод үндэсний өдрийн хүрээнд бүх нийтээр мод, сөөг тарих, арчлан ургуулах үйл хэрэгт идэвхтэй оролцож, сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэхийг Монгол Улсын нийт ард иргэд, айл өрх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хөгжлийн түнш байгууллагууд, хандивлагч нарт уриалсугай; | Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай 2025-04-03 Дугаар 2025_44 | 100 |
| Хэсгийн дундаж үнэлгээ | | | 100 |

## Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн зөвлөмжийн хэрэгжилт (Хүснэгт 6.)

| Д/д | Зүйл, заалт дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Дундаж хувь |
|---|---|---|---|
| Гурав. Засаглал | | | |
| 1 | Ажиллах хүч гадаадаас авч буй байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хууль зүй дотоод хэргийн яам, Зам, тээвэр, барилга хот байгуулалтын яам, Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Тагнуулын ерөнхий газар, Улсын мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын хамтарсан шалгалт хийж, түүний мөрөөр авах арга-хэмжээг хэрэгжүүлэх зөвлөмж, чиглэлийг холбогдох байгууллагад хүргүүлэх, дүнг гуравдугаар улиралд багтаан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах; | Гаадын иргэдэд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгож, ажлын байрны төлбөрөөс чөлөөлж байгаа тухай; 2010-04-09 Дугаар 2010_15/12 | Хэрэгжих боломжгүй |
| 2 | Хүүхэд үрчлэлт, хүн худалдаалах гэмт хэрэг, гадаадын иргэнтэй гэр бүл болж байгаа асуудлаар нарийвчилсан судалгаа хийж, Гэр бүлийн тухай болон бусад холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулан Улсын Их Хуралд өргөн барих; | Иргэдийг хүн худалдаалах гэмт хэрэгт өртөхөөс хамгаалах асуудлын тухай 2011-03-17 Дугаар 2011_13/10 | 50 |
| 3 | Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 01/01тоот зөвлөмж, түүнийг хэрэгжүүлэх нэгдсэн зохицуулалтын эрх зүйн хүрээнд Засгийн газрын 2013 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 169 дүгээр тогтоолоор баталсан Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журмыг хэрэгжүүлж ажиллах; | Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай 2013.01.08 Дугаар 2013_01/01 | 100 |
| 4 | Дээд шатны байгууллага, албан тушаалтны зохих чиглэлгүйгээр гадаадын албаны болон аж ахуйн төлөөлөлтэй уулзах; | | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | Гадаад харилцааны яам олон улсын гэрээ байгуулах үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авах:<br>4.1.Улс хоорондын болон Засгийн газар хоорондын гэрээ байгуулах үйл ажиллагааг арга зүйн зөвлөмжөөр хангаж, улсын хэмжээнд уялдуулан зохицуулах;<br>4.2.Олон улсын гэрээний тухай хуулийг шинэчлэх, байгууллага хоорондын гэрээний зохицуулалтыг хуульчлах, гадаад харилцааны тухай хуулийн төсөл боловсруулах;<br>4.3.Байгуулах гэрээ бүрээр дүгнэлт гарган орчуулгыг хянан албажуулах;<br>4.4.Энэхүү зөвлөмжийг төрийн төв болон орон нутгийн байгууллагуудад хүргүүлж ажиллах; | Олон улсын гэрээ байгуулах үйл ажиллагааг сайжруулах тухай 2026.09.22 Дугаар 2014_46/26 | 100 |
| 6 | Улс хоорондын болон Засгийн газар хоорондын гэрээ байгуулахдаа дараах журмыг чанд баримтлах:<br>1.1.Гэрээ байгуулахдаа үндэсний язгуур ашиг сонирхолыг үндэс болгох;<br>1.2.Гэрээг Үндсэн хууль болон бусад хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд нийцүүлэх;<br>1.3.Гадаад харилцааны сайд Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дугаар хэсгийн 4-т заасны дагуу гэрээ байгуулах чиглэлээр үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж, гол хариуцлага хүлээх;<br>1.4.Тодорхой гэрээ байгуулах асуудлаар Гадаад харилцааны яамтай зөвшилцөн төсөл, орчуулгыг нь албан ёсоор хянуулж дүгнэлт гаргуулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж байх;<br>1.5.Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн 5.10, 5.11-д заасныг баримтлан гэрээний төслийг заавал монгол хэлээр үйлдэх;<br>2.Байгууллага хоорондын гэрээ байгуулахдаа Гадаад харилцааны яамны санал, дүгнэлтийг авч, байгуулсан гэрээг Гадаад харилцааны яаманд бүртгүүлэх.<br>3.Гэрээ байгуулахаар яриа хэлэлцээ хийхдээ;Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай; Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 01/01 дүгээр зөвлөмж болон Засгийн газрын 2013 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 169 дүгээр тогтоолоор баталсан Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журмыг мөрдлөг болгох; | | 100 |
| 7 | Байгууллага хоорондын гэрээ байгуулахдаа Гадаад харилцааны яамны санал, дүгнэлтийг авч, байгуулсан гэрээг Гадаад харилцааны яаманд бүртгүүлэх; | | 100 |
| 8 | Үндэсний эв нэгдэл, нийгмийн тогтвортой байдалд сөрөг нөлөөлөх эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах; | Үндэсний эв нэгдэл, язгуур ашиг сонирхлыг дээдлэн бэхжүүлэх тухай<br>2017-06-20<br>Дугаар 2017_17/13 | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| 9 | Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллагаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан зөвлөмжүүдийг төрийн бүх шатны байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах; | Мөнгө угаахтай тэмцэх зарим арга хэмжээний тухай 2017-07-19 Дугаар 2017_19/5 | 100 |
| Хэсгийн дундаж үнэлгээ | | | 93.7 |

Засгийн газрын тогтоолын хэрэгжилт (Хүснэгт 7.)

| Д/д | Зүйл, заалт дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Дундаж хувь |
|---|---|---|---|
| Гурав. Засаглал | | | |
| 1 | Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт татах зорилгоор гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж болон иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэж ажиллахыг бүх шатны төрийн захиргааны байгууллагад үүрэг болгосугай; | Экспортын орлогыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-02-19 Дугаар 2025_94 | 100 |
| 2 | Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхтэй холбогдуулан улсын хилийн зурваст бүтээн байгуулалтын хаалттай бүс байгуулах асуудлыг шийдвэрлэхийг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн), Гадаадын иргэн, харьяатын газар (Н.Ууганбаяр), Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Энхбат, "Тавантолгой төмөр зам" ХХК (Б.Дүгэржав)-д даалгасугай; | Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хаалттай бүс байгуулах тухай 2025-03-26 Дугаар 2025_157 | 100 |
| 3 | Бүтээн байгуулалтын хаалттай бүс байгуулах асуудлаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын холбогдох байгууллагатай тохиролцох яриа хэлэлцээ хийхийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн), Гадаадын иргэн, харьяатын газар (Н.Ууганбаяр)-т даалгасугай; | | 100 |
| 4 | Аялал жуулчлалын дэд бүтцийн хөгжлийг дэмжих зорилгоор Бүгд Найрамдах Солонгос Улс-Хөвсгөл аймгийн Мөрөн сум чиглэлд олон улсын шууд нислэг үйлдэх нөхцөлийг бүрдүүлж, нисэх буудлыг 4C ангиллын шаардлагад нийцүүлэн өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр бэлтгэл ажлыг хангаж, шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг 2026 оны улсын төсөвт тусган шийдвэрлүүлэхийг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан, Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Төмөрбаатар нарт, жуулчдыг саадгүй нэвтрүүлэх боломжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэхийг Гадаадын иргэн, харьяатын газар (Н.Ууганбаяр), Хил хамгаалах ерөнхий газар (Ж.Бямбасүрэн), Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал)-т; | Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-04-28 Дугаар 2025_204 | 100 |
| 5 | Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж | 2027 оныг “Эрүүл мэндийг дэмжих | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай; | жил" болгон зарлах тухай 2025-11-05 Дугаар 2025_154 | |
| 6 | Төрийн байгууллагын үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй, шуурхай байдлыг алдагдуулахгүйгээр Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу төрийн албан хаагчийг долоо хоногийн ажлын нэг өдөр зайнаас цахим сүлжээгээр ажиллуулах, ажлын цагийг уян хатан байх дотоод зохион байгуулалтын арга хэмжээ авах, хуульд зааснаас бусад тохиолдолд нийтээр амрах баярын өдрүүд болон долоо хоногийн амралтын өдрүүдэд ажиллуулахгүй байхыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай; | Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2026-04-08 Дугаар 2026_119 | 100 |
| 7 | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем болон төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааг дэмжихээс бусад зорилгоор төрөөс иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээ үзүүлэх мэдээллийн системийг шинээр хөгжүүлэхэд төсвийн хөрөнгө зарцуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нар, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт хориглосугай; | Бизнесийн орчныг дэмжих зарим арга хэмжээний тухай 2026-04-15 Дугаар 2026_127 | 100 |
| Хэсгийн дундаж үнэлгээ | | | 100 |

Ерөнхий сайдын захирамж хэрэгжилт (Хүснэгт 8.)

| Д/д | Зүйл, заалт дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Дундаж хувь |
|---|---|---|---|
| Гурав. Засаглал | | | |
| 1 | Хөрөнгө оруулагч, аж ахуй эрхлэгчдэд хууль бусаар дарамт учруулсан, хүнд суртал болон ёс зүйн алдаа гаргасан, эрх ашгийг нь хохироосон, авлига, ашиг сонирхлын зөрчилд холбогдсон төрийн захиргааны байгууллагын албан хаагчдад хариуцлага тооцох арга хэмжээг зохион байгуулах; | Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-08-13 Дугаар 2025_64 | 100 |
| 2 | Нийгмийн шударга ёсыг бэхжүүлэх зорилтын хүрээнд Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа авлигын эсрэг арга хэмжээг бүх талаар дэмжиж, хяналт, хариуцлагаа сайжруулан, авлига, ашиг сонирхлын эсрэг "Шүгэл үлээгч", "Шударга ёсны дуу хоолой" болж ажиллахыг нийт иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бизнес эрхлэгчдэд уриалсугай; | | 100 |
| Хэсгийн дундаж үнэлгээ | | | 100 |

Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилт (Хүснэгт 9.)

| Д/д | Зүйл, заалт дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Дундаж хувь |
|---|---|---|---|
| Гурав. Засаглал | | | |
| 1 | Говийн бүсийн байгаль, газар зүйн онцлогт түшиглэсэн хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд аялал жуулчлалын маршрутыг батлах болон тухайн маршрутаар зорчих гадаадын иргэдэд Монгол Улсын хилээр нэвтрэх үнэмлэх олгох асуудлыг холбогдох олон улсын гэрээ, хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх боломжийн талаар судалж, танилцуулахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 23 дугаар хуралдааны тэмдэглэл | 50 |

| | | | |
|---|---|---|---|
| | сайд Ч.Номин, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл нарт даалгав.”(2.2.“Говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай”) | 2025-05-12 Дугаар 2025_23 | |
| 2 | Өөрийн эрхлэх асуудлын хүрээний орон нутаг дахь удирдлагын босоо тогтолцоотой нэгжийн үйл ажиллагааны бүтэц, чиг үүрэгт шинжилгээ, тооцоо судалгаа хийж, харьяа аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, иргэдийн саналыг үндэслэн байгууллагын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт оруулах өөрчлөлтийн санал боловсруулж, танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд; | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 24 дүгээр хуралдааны тэмдэглэлд 2025-05-21 Дугаар 2025_24 | 50 |
| 3 | Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх, цахимжуулж ажиллахыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт, алдаа, зөрчил гаргасан албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүдэд, хяналт тавьж, салбар дундын уялдаа зохицуулалтыг хангаж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод; | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 09 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-07-23 Дугаар 2025_09 | 100 |
| 4 | Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдийг Монгол Улсын визийн шаардлагаас чөлөөлсөн хугацааг сунгах асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр нарт даалгав; | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 34 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-12-24 Дугаар 2025_34 | 100 |
| 5 | “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов; | Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 28 ний өдрийн 04 дугаар хуралдааны тэмдэглэл 2026-01-28 Дугаар 2026_04 | 100 |
| 6 | Өөрийн байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний мэдээллийг “services.khurdan.gov.mn” цахим системд 2026 оны 04 дүгээр сард багтаан бүртгэх, цаашид төрийн үйлчилгээний мэдээллийн өөрчлөлтийг цаг тухайд нь цахим системд бүртгэж хэвшихийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нар болон төсвийн байгууллагуудын удирдлагад; | Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 06 дугаар хуралдааны тэмдэглэл 2026-02-11 Дугаар 2026_06 | 50 |
| 7 | Иргэд, олон нийтийн хэрэгцээ, шаардлагыг соргог мэдэрдэг, асуудал гарсны дараа бус гарахаас өмнө урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх, ард иргэдээс хүсэн хүлээж байгаа хариуцлагатай төр, төрийн үйл ажиллагааны ил тод байдал, нийгмийн шударга ёсны зарчимд нийцсэн, тэдний оролцоог хангасан, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн шийдвэр гаргахад идэвх, | Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 25 ны өдрийн 07 дугаар хуралдааны тэмдэглэл 2026-02-25 | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | санаачилгатай, бодит үр дүнтэй ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав; | Дугаар 2026_07 | |
| 8 | Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг доор дурдсан албан тушаалтнуудад даалгав. 1.Төрийн албан хаагчийн ажлын эхлэх цагийг 07:00;08:30, дуусах цагийг 16:00;17:30 цагийн хооронд уян хатан байхаар зохицуулах, долоо хоногийн ажлын нэг өдөр зайнаас цахим сүлжээгээр ажиллах хуваарийг гарган мөрдүүлэхтэй холбогдуулан төрийн байгууллага хоорондын ажлын уялдааг хангалзан зохицуулалт хийх, эрхлэх асуудлын хүрээний байгууллагын үйл ажиллагаа хэвийн, тасралтгүй, шуурхай явагдаж буй эсэхэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 15- ны өдрийн 14 дүгээр хуралдааны тэмдэглэл 2026-04-15 Дугаар 2026_14 | 100 |
| 9 | Чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор эрхэлсэн асуудлын хүрээний бодлого хэрэгжүүлэх, гүйцэтгэх зарим чиг үүргийг чиг үүргийн шинжилгээний дүгнэлт, саналтай уялдуулан Засгийн газрын агентлаг, харьяа байгууллагад шилжүүлэх талаар зохих арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Боловсролын сайд Л.Энх-Амгалан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ж.Алдаржавхлан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ч.Номин, Эрчим хүчний сайд Б.Найдалаа, Эрүүл мэндийн сайд Э.Батшугар нарт; | Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 13- ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэл 2026-05-13 Дугаар 2026_18 | 100 |
| 10 | Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын харьяа байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн саналыг хууль тогтоомжид нийцүүлэн нэгтгэн боловсруулж ирүүлэхийг Засгийн газрын гишүүдэд, Засгийн газрын хуралдаанд нэгтгэн танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаярт; | | 50 |
| Хэсгийн дундаж үнэлгээ | | | 80 |

Монгол Улсын Засгийн Газрын албан даалгаварын хэрэгжилт (Хүснэгт 10.)

| Д/д | Зүйл, заалт дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Дундаж хувь |
|---|---|---|---|
| Гурав. Засаглал | | | |
| 1 | Эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд “Хариуцлагатай шуурхай алба"-ыг байгуулж, нэгдсэн удирдлага, мэдээллийн урсгалыг зохион байгуулж, тогтмол хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай; | Сар шинийн баярын өдрүүдэд онцгой байдлын өндөржүүлсэн бэлэн байдлыг хангах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах “Хариуцлагатай шуурхай алба" ажиллуулах тухай | 100 |
| 2 | Албан даалгаврын хэрэгжилтийг 2026 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 08:00 цагаас 2026 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 09:00 цаг хүртэлх хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулж, аюул, осол, онцгой нөхцөл байдлын мэдээллийг Засгийн газрын Шуурхай албанд 2 цаг тутамд хүргүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай; | | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | 2026-02-11 Дугаар 2026_01 | |
| 3 | Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 1.1.1.иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр хүргэж байгаа үйлчилгээг оновчилж, хүсэлт шийдвэрлэлтийн явцыг тухай бүр иргэн, хуулийн этгээдэд эргэн мэдэгдэх нөхцөлийг бүрдүүлэх; | Төрийн зарим үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх талаар авах зарим арга хэмжээний тухай<br><br>2026-02-11<br><br>Дугаар 2026_02 | 100 |
| 4 | Эрхлэх асуудлын хүрээнд ашиглаж байгаа мэдээллийн системийг мэдээллийн системийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем (system.gov.mn)-д бүртгэх; | | 100 |
| 5 | Төрийн байгууллага ашиглаж байгаа мэдээллийн системд гадаадын иргэнийг таньж, баталгаажуулан цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх; | | 100 |
| 6 | Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр иргэн, хуулийн этгээдэд хүргэхдээ Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ийг ашиглах, ижил зорилготой мэдээллийн систем, гар утасны аппликейшныг тус системд нэгтгэх; | | 100 |
| 7 | Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаярт: 1.2.1.Төрийн мэдээлэл солилцооны (ХУР) системийг ашиглан төрийн байгууллага хооронд солилцох боломжтой мэдээллийг цаасан хэлбэрээр иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээг харьяа байгууллагын хэмжээнд авах; | | 50 |
| 8 | иргэн, хуулийн этгээдээс цахим шуудангаар болон хуульд заасан бусад цахим хэлбэрээр илгээсэн, хүлээн авсан хаалттайгаас бусад мэдээлэл, баримт бичгийг цахим хэлбэрээр архивлах асуудлыг холбогдох стандартад тусгах арга хэмжээг эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулах; | | 100 |
| 9 | Талуудын 17 дугаар Бага хурал (COP17)-ын бэлтгэл ажлыг үр дүнтэй зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх ажлыг эрхлэх асуудлын хүрээнд шуурхай зохион байгуулж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; | Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурал (COP17)-ыг зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай<br>2026-04-15<br>Дугаар 2026_07 | 100 |
| 10 | Талуудын 17 дугаар Бага хурал (COP17)-ыг зохион байгуулах хүртэлх хугацаанд олон улсын болон дотоодын томоохон чуулга уулзалт, хурал, уулзалтууд, бусад арга хэмжээ зохион байгуулахгүй байхыг Засгийн газрын гишүүдэд; | | 100 |
| Хэсгийн дундаж үнэлгээ | | | 95 |

## Дүгнэлт, санал

Тайлант хугацаанд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналтад авсан 33 шийдвэрийн 53 зүйл, заалтын хэрэгжилт 92.3 хувьтай үнэлэгдлээ.

Дээрх “засаглал”-ын буюу эрх зүйн орчинд хамаарах шийдвэрийг хэрэгжүүлэхэд зохион байгуулалтын арга хэмжээ авсан, холбогдох шийдвэр гарч тодорхой үр дүнд хүрсэн буюу “хэрэгжих шатандаа” байгаа дараах арга хэмжээний биелэлтийг эрчимжүүлэх шаардлагатай. Үүнд:

Монгол Улсын хууль (ГИЭЗБт): 22.2. Энэ хуулийн 22.1.2-т заасан өвчний жагсаалтыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

Хэрэгжилт: Эрүүл мэндийн яамнаас 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 2/5924 дугаар албан бичгээр “Монгол Улсад орохыг үл зөвшөөрөх, нийгмийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй өвчний жагсаалт”-ын төсөлд санал авахаар ирүүлсний дагуу холбогдох саналыг боловсруулж, 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 01/2308 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн. (50 хувь)

Улсын Их Хурлын тогтоол 2024-06 ЁЗДБХ: 1.1.Байнгын хорооны 2023 оны 10 дугаар тогтоолын 1 дэх заалтын 1, 3, 6. 7. 8. 9 дэх дэд заалтад заасан арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, нийгмийн болон монгол хүний ёс суртахууны түвшин, чиг хандлагыг тодорхойлох суурь судалгаа хийж, судалгаанд суурилсан бодлого боловсруулах.

Хэрэгжилт: Гадаадын иргэн, харьяатын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд "Ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тодорхойлох судалгаа хийж, үр дүнд үндэслэн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэх" арга хэмжээ, Ёс зүйн дэд хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд "Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах" арга хэмжээ, Төрийн албан хаагчийн 2026 оны сургалтын төлөвлөгөөнд "Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах" арга хэмжээг тус тус тусган баталсан. Түүнчлэн байгууллагын даргын 2024 оны А\454 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8.1.1, 11.8, 11.10-т ёс зүйн хариуцлагатай холбогдох зохицуулалтыг нарийвчлан тусгаж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжид заасан харилцааг хэрэгжүүлж байна. Ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөл, түүнд нөлөөлөх дотоод хүчин зүйлийг тогтоох зорилгоор Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал”-ын дагуу байгууллагын 131 албан хаагчаас 12 асуулга бүхий судалгаа авч 05 дугаар сарын 29-ний өдөр үр дүнг нэгтгэлээ. (50 хувь)

Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн зөвлөмж 2011-13/10:

Засгийн газрын тогтоол 2025-154: Хүүхэд үрчлэлт, хүн худалдаалах гэмт хэрэг, гадаадын иргэнтэй гэр бүл болж байгаа асуудлаар нарийвчилсан судалгаа хийж, Гэр бүлийн тухай болон бусад холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулан Улсын Их Хуралд өргөн барих.

Хэрэгжилт: “Улс хоорондын үрчлэлтийн эрх зүй ба гадаадын иргэн, гэр бүлд үрчлэгдсэн Монгол Улсын харьяат хүүхдийн үрчлэлтийн дараах нөхцөл байдал” сэдэвт судалгааны ажлыг эхлүүлж, нийт 4 бүлэг судалгааны ажлаас 3 бүлгийг

боловсрууллаа. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/283 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Мөн УИХ-ын гишүүн, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг Байнгын хороо болон Чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч буюу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдөр баталсан "Ажлын хэсэгт"-т тус байгууллагаас Иргэний харьяаллын газрын ахлах мэргэжилтэн ажиллаж,  Хууль зүйн байнгын хорооны 03 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанд хуульд тусгах саналаа танилцуулсан. (50 хувь)

Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл 2025-23: Говийн бүсийн байгаль, газар зүйн онцлогт түшиглэсэн хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд аялал жуулчлалын маршрутыг батлах болон тухайн маршрутаар зорчих гадаадын иргэдэд Монгол Улсын хилээр нэвтрэх үнэмлэх олгох асуудлыг холбогдох олон улсын гэрээ, хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх боломжийн талаар судалж, танилцуулахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл нарт даалгав.”(2.2.“Говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай”)

Хэрэгжилт: Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт ”Хил орчмын аялал жуулчлалын нутаг дэвсгэрт энэ хуулийн 18.1-д заасан гадаадын иргэн зорчих маршрутыг хууль зүйн болон аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэж заасны дагуу “Хил орчмын аялал жуулчлалын маршрут”-ыг баталгаажуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдаас 06 дугаар сарын 15-ны өдрийн 1/3209 дүгээр албан бичгээр Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдад хүргүүлсэн болно.

Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын “Аялал жуулчлалын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх тухай хэлэлцээр”-ийн 1.1-д "Нэг жилийн хүчинтэй хугацаатай олон удаагийн “орох, гарах БНХАУ-ын зорчих үнэмлэх” эзэмшигч бүлэг жуулчдын ахлагч, эсхүл хөтөч-орчуулагч нь визгүйгээр Монгол Улсад нэвтэрнэ". 1.2-д "Бүлэг жуулчдын ахлагч, эсхүл хөтөч-орчуулагчийг дагалдан Монгол Улсад зорчих гурван сарын хүчинтэй хугацаатай нэг удаагийн “хил орчмын аялал жуулчлалын зориулалт бүхий орох, гарах БНХАУ-ын зорчих үнэмлэх”-тэй БНХАУ-ын бүлэг жуулчид “нэрсийн жагсаалт”-аар Монгол Улсад нэвтэрнэ." гэж тусгасан.

Дээрх хэлэлцээрийн дагуу Монгол Улсад нэвтрэх бүлэг жуулчдын нэрсийн жагсаалтын загварт өөрчлөлт оруулах талаарх саналыг 06 дугаар сарын 15-ны өдрийн 01/1174 дүгээр албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. (50 хувь)

Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл 2026-06: Өөрийн байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний мэдээллийг

“services.khurdan.gov.mn” цахим системд 2026 оны 04 дүгээр сард багтаан бүртгэх, цаашид төрийн үйлчилгээний мэдээллийн өөрчлөлтийг цаг тухайд нь цахим системд бүртгэж хэвшихийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нар болон төсвийн байгууллагуудын удирдлагад;

Хэрэгжилт: "Төрийн үйлчилгээний бүртгэл" нэгдсэн систем (services.khurdan.gov.mn)-д тус байгууллагын нийт 53 үйлчилгээ бүртгэгдсэнээс одоогийн байдлаар 50 үйлчилгээ цахим хэлбэрт бүрэн шилжсэн. Эдгээрээс 5 үйлчилгээг "e-mongolia.mn" системээр, 45 үйлчилгээг "isf.mn" системээр дамжуулан иргэдэд хүргэж байгаа бол бичиг баримт нягтлах, биет хяналт шалгалт хийх болон бусад байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай 3 үйлчилгээ (архивын баримтаас хуулбар олгох, хилийн боомтод цаасаар виз олгох, утсаар зөвлөгөө мэдээлэл өгөх)-г хиймэл оюунд суурилсан технологийн шийдлээр үе шаттай цахимжуулж байна. (50 хувь)

Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл 2026-18: Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын харьяа байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн саналыг хууль тогтоомжид нийцүүлэн нэгтгэн боловсруулж ирүүлэхийг Засгийн газрын гишүүдэд, Засгийн газрын хуралдаанд нэгтгэн танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаярт.

Хэрэгжилт: Тэмдэглэлийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд өмнө хүргүүлсэн бүтцийн саналыг байгууллагын даргын 05 дугаар сарын 29-ний өдрийн 01/1030 дугаар албан бичгээр татах хүсэлт хүргүүлж, дахин боловсруулж эхэллээ. (50 хувь)

Засгийн Газрын албан даалгавар 2026-02: 1.2.1.. 1.2. Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаярт: 1.2.1.Төрийн мэдээлэл солилцооны /ХУР/ системийг ашиглан төрийн байгууллага хооронд солилцох боломжтой мэдээллийг цаасан хэлбэрээр иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээг харьяа байгууллагын хэмжээнд авах.

Хэрэгжилт: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамтай 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр байгуулсан №Ц/ХУР-2025/436, №Ц/ХУР-2025/436-97, Ц/ХУР-2025/436-102, №Ц/ХУР-2025/436-144 дугаар бүхий “Үндсэн систем (ХУР)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ээр Боловсролын яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар гэсэн нийт 6 байгууллагын 32 төрлийн сервисээр мэдээлэл авч, "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан" (isf.mn) системд холбох хөгжүүлэлтийг дуусган үйлчилгээнд нэвтрүүлсэн. Харин Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь тухайн бүртгэлийн системээ гүйцэтгэгч байгууллагаас хүлээн аваагүй, нэмэлт сервис хөгжүүлэлт хийх боломжгүйгээс хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл, Статистикийн хороонд гадаадын иргэний хаяг бүртгэх бүртгэлийн систем байхгүйгээс хаягийн

тодорхойлолт, Гадаадын хөрөнгө оруулалтын газарт бүртгэлийн систем байхгүйгээс хөрөнгө оруулагчийн тодорхойлолтыг isf.mn системд холбох боломжгүй байна. Мөн байгууллагаас 13 сервисээр 25 байгууллагад мэдээлэл хүргэж байна. (50 хувь)

“Хэрэгжих боломжгүй” буюу хуулиар эрх олгосон, бусад шийдвэрээр чиглэл өгсөн 1 зүйл заалт байгаа нь:

Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн зөвлөмж 2010-15/12: Ажиллах хүч гадаадаас авч буй байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хууль зүй дотоод хэргийн яам, Зам, тээвэр, барилга хот байгуулалтын яам, Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Тагнуулын ерөнхий газар, Улсын мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын хамтарсан шалгалт хийж, түүний мөрөөр авах арга-хэмжээг хэрэгжүүлэх зөвлөмж, чиглэлийг холбогдох байгууллагад хүргүүлэх, дүнг гуравдугаар улиралд багтаан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах.

Хэрэгжилт: Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 115 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд 2026 оны төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг цуцалсан тул энэ хагас жилд дээрх асуудлаар хяналт, шалгалт хийгдээгүй болно. (хэрэгжих боломжгүй)

Мөн байгууллагын хэмжээнд энэ оны хагас жилийн байдлаар хяналтад авч хэрэгжүүлж буй 53 зүйл заалтаас хяналтаас хасуулах саналтай дараах зүйл, заалтууд байна. Үүнд:

Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолын хавсралтад заасны дагуу “бүрэн хэрэгжсэн”, “бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон” болон “цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон” Монгол Улсын хуулийн 4 зүйл, заалт, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 1 зүйл заалт, албан даалгаврын 2 зүйл, заалт нийт 4 шийдвэрийн 7 зүйл заалт байгаа юм.

Цаашид нийт хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн чанарт анхаарч, үр дүнг бууруулахгүй ажиллахыг санал болгож байна.

--oo0oo--